

Хятад үсгээр галигласан зарим кидан (хятан)
үгийг сэргээсэн нь

Эндрю Шимүнек
/Индиана их сургууль/

Олон жилийн турш кидан хэлний талаар маш чухал, үр дүнтэй судалгаа хийгдсээр байгаа хэдий ч хятадын түүх сударт байгаа, хятад үсгээр галигласан үгсийг эрдэмтэд сонирхон үзээгүй юм уу ер нь дахин авч үзүүштэй кидан үгс одоо хүртэл харьцангуй олон байна.

Энэхүү товч өгүүлэлд хятадын түүх сударт буй зарим кидан үгийг авч үзэх зорилготой юм.

Эдгээр үгийг авч үзэхээс өмнө үүний авианы хэлбэрийг сэргээх аргазүйн тухай хэдэн тайлбар өгвөл зүйтэй гэж бодож байна. Нэгдүгээрт, миний бие хэл судлаач, Хавай их сургуулийн профессор Вовинь (Vovin) (2003)-ы саналыг дагаж, *Ци-дань гуо-чжы* (契丹國志) хэмээх түүх сударт буй кидан үгс нь дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэл (Late Middle Chinese)-ээр галиглагдсан гэж үзэж байна. Хятад үгсийнх нь дундад үеийн хятад хэлний хожуу үеийн дуудлагын тухайд бол би голдуу канадын эрдэмтэн, хятад хэлний алдарт судлаач Пөөлийбланьк (Pulleyblank) (1984, 1991)-ын сэргээснээр авч үзэж байгаа боловч мажарын эрдэмтэн Чонгор (Csongor) (1953, 1954, 1960, 1962) болон америкийн эрдэмтэн Коблин (Coblin) (1991, 1994)-ыг дагаж, эдгээр үгийг галигласан дундад үеийн хятад хэлний хожуу үеийн энэхүү хойд аялгуунд үеийн эцэст орсон *-r гийгүүлэгч (өмнө нь *-t гийгүүлэгчээс үүссэн) байсан гэж үзэж байна. Вовинь (2003) үүнийг кидан хэлний үеийн эцэст орсон *-r, *-γ, *-t зэрэг гийгүүлэгчийг галигладаг байсан гэж тайлбарлажээ. Энэ таамаглалыг буруу гэж үзэх учир шалтгаан байхгүй бөгөөд үнэн хэрэг дээрээ *Ци-дань гуо-чжы*-д байгаа кидан үгсийг сэргээхдээ энэ таамаглалын дагуу явбал монгол төрлийн хэлнүүд ба манж-түнгүүс хэлнүүдийн үгстэй утгазүй болоод авиасудлалын хувьд үнэмшмээр холбоотой хэлбэрүүд гарч ирнэ. Энэ нь уг асуудалд үндэслэлтэй хандаж байгаагийн баримт гэж үзмээр байна. Бид энэ өгүүлэлдээ Вовинийг дагаж, кидан хэлний үеийн эцэст орсон *-r, *-γ, *-t гийгүүлэгчийг галиглаж байсан, дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлний хойд аялгууны авиаг цаашдаа *-R үсгээр тэмдэглэнэ.

Вовиний бичсэнээр (2003:238):

"All previous research on [the] Chinese transcriptions [of Kitan] suffers from a major setback—[an] anachronistic approach to Chinese historical phonology."

Монголчилбол “хятад үсгээр галигласан кидан үгсийг авч үзсэн өмнөх бүх судалгаанд нэг гол саад тотгор учирсан юм. Юу гэвэл, хятад хэлний түүхэн авиасудлалын асуудалд он цагийн хувьд буруу хандсан байдаг”. Урьд нь кидан хэлийг судалж байсан эрдэмтэд, заримдаа хэрэгцээний улмаас (жишээлбэл, тухайн үед Юань (元) улсын үеийн юм уу дундад үеийн хятад хэлний сэргээсэн хэлбэр байхгүй байсны улмаас) хятадын түүх судруудад байгаа, хятад үсгээр галигласан кидан үгсийг зөвхөн нэг үеийн дуудлагаар уншдаг байжээ. Голдуу Юань улсын үеийн хятад хэлний уншлагын дагуу (жишээлбэл, германы эрдэмтэн Франке (Franke) 1976) аль эсвэл, бүр эртний судалгаанд орчин цагийн хятад хэлний уншлагын дэгээр (жишээлбэл, японы эрдэмтэн Ширатори (白鳥) 1912, 1913) явдаг байжээ. Гэхдээ эдгээр түүх судар өөр өөр цагт бичигдсэн гэсэн бодит байдлыг тунгаан бодвол, янз бүрийн түүх судрын бүтээлд кидан хэлний үгсийг галигласан хятад хэл нь мөн л янз бүрийн цаг үед холбогдож болох юм. Тухайлбал, дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэл (8-9-р зуун) болон Юань улсын үеийн хятад хэл (13-14-р зуун)-ийг үүнд бодолцох хэрэгтэй. Би *Ляо шы* (遼史)-д байгаа, хятад үсгээр галигласан кидан үгсийг дараахь хоёр аргаар авч үзэж байна. Үүнд:

1. *Ляо шы*-д тохиолдсон, бас ав адилхан хэлбэрээр нь өмнөх түүх судрууд (жишээлбэл *Ци-дань гуо-чжы*-д байгаа үгсийг *Ляо шы*-гийн эмхэтгэгч буюу Тогтоо (脱脱) өмнөхийн эх сурвалжаас хуулж авсан гэж таамаглаж байна.
2. Өмнөх эх сурвалж дотор тохиолддоггүй бөгөөд зөвхөн *Ляо шы* болон хожмын сурвалжуудад тохиолддог үгсийг сэргээхдээ Юань улсын үеийн хятад хэлний дуудлагыг баримталдаг. Эдгээр үгийг нь Тогтоо тухайн үеийн зүүн хойдод үлдэж хоцорсон киданчуудаас сурсан байж болох юм гэж үзмээр байна.

Энэ аргазүйг баримталбал авианзүйн хувьд үндэслэлтэй, бас монгол болоод манж-түнгүүс төрлийн хэлнүүдийн хэлбэрүүдтэй ойролцоо хэлбэр ч гарч ирнэ. Үүнд:

1. *aju [阿主] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд *ʔa-tʃyǎ, Юань улсын үеийн хятад хэлэнд *ɔ-tʃy) “эцэг, өвөө (父祖)”. Энэ үг *Ляо шы*-гийн 116-р бүлгийн 2-р хуудасны 1-р талд байгаа бөгөөд дагуур хэлний [atʃa:] “эцэг, аав”, баарин, ар хорчин аман аялгууны [ɛdʒɛ:] “эцэг, аав”, шар юугар буюу зүүн юугар хэлний [adʒa] “эцэг”; бас зүүн халх аялгууны Хэнтийн салбар аман аялгууны [adʒa:] “эцэг, аав; өвөө”, үзэмчин аялгууны [a:dʒi:] “эцэг/аав”, дариганга аман аялгууны [a:dʒæ:] “эхнэр” (Амаржаргал 1988, 38, 55 дахь тал), горлос, жалайд, хорчин, хэйлунцянгийн дөрвөд салбар аман аялгууны [adʒɛɛ] “аав” (Тодаева 1981, 105 дахь тал), жарууд, улаанцав

салбар аман аялгууны [adʒaa] “эцэг” (Тодаева 1981, 271 дэх тал) зэрэг хэлбэрүүдтэй гарал нэгтэй гэж үзмээр байна.

2. *g^lammu- [監母] (Юань улсын үеийн хятад хэлэнд *kjam-mu) “үлдээх, дамжуулах (遺留)”. Энэ үг *Ляо шы*-гийн 116-р бүлгийн 13 хуудасны 2-р талд, 31-р бүлгийн 3-р хуудасны 2-р талд, *Ляо шы шы-и* (遼史拾遺) хэмээх судрын 23-р бүлгийн 427-р хуудсанд байгаа бөгөөд дагуур хэлний [g^lanə-] “зөөх, шилжүүлэх” гэдэгтэй гарал нэгтэй гэж үзүүштэй байна.

3. *mur / *muri [沒里] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд *muR-li) “гол, мөрөн (河)”. Энэ үг *Ляо шы*-гийн 39-р бүлгийн 2-р хуудасны 1-р талд, *Ци-дань гуо-чжы*-гийн 2 дахь талд, *Ляо чжы* (遼志)-гийн 1 дэх талд байгаа бөгөөд дагуур хэлний [mur] “мөрөн”, монгол бичгийн *mören* “мөрөн”, хорчин аман аялгууны [murən], халх аялгууны [mөрән] мөрөн зэрэг үгтэй гарал нэгтэй хэмээн үзмээр байна.

4. *son [算] (юань улсын үеийн хятад хэлний *sɔn) “цээж ба хэвлий (心腹)”. Энэ үг *Ляо шы*-гийн 31-р бүлгийн 1-р хуудасны 2-р талд, 116-р бүлгийн 12-р хуудасны 2-р талд байгаа бөгөөд говийн халхын аялгууны [sɔn] “айрагны модон сав”, монгол улсын Архангай, Булган аймгийн халх аялгууны [sɔn] “хөхүүр” (Амаржаргал 1988, 288 дахь тал) гэсэн хоёр үгтэй холбоотой байж магадгүй боловч энэ таамаглал утгазүйн хувьд эргэлзээтэй байж мэдэх юм.

5. *sia [捨, 奢, 舍] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд *sia) “сайн (好)”. Энэ үг *Ляо шы*-гийн 53-р бүлгийн 8-р хуудасны 1-р талд, *Ци-дань гуо-чжы*-гийн 27 бүлгийн 187 дахь талд, *Ляо чжы*-гийн 9 дэх талд, мөн *Янь бэй цза-цзи* (燕北雜記)-д байгаа. *Ляо чжы*-д байгаа хэлбэр нь [捨] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлний *ʃhip) боловч үүнийг *Ци-дань гуо-чжы*-д байгаа, хамгийн эрт тохиолдсон байж болох хэлбэр нь буюу [捨] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлний *sia) үсгийн бичгийн алдаа гэж ойлговол зүйтэй гэж бодож байна. Кидан хэлний энэ үг монгол бичгийн *sayin*, манж хэлний шивээ аялгууны [ʃen] “сайн”, Мин (明) улсын үеийн зөрчид хэлний *sa(j)in [賽因] (Юань улсын үеийн хятад хэлээр *saj-jin) “сайн (好)” (Kane 1989:273), манж хэлний бала (巴拉) аялгууны [tsai] (ЧЖАО 2001:113), сонгодог манж хэлний *sa(y)in* “сайн”, монгол хэлний халх аялгууны /sain/ **сайн**, баарин, ар хорчин, хорчин, горлос, огнууд, найман, хишигтэн, харчин, түмэд аман аялгууны [sen:], жалайд, хэйлунцзянгийн дөрвөд аман аялгууны [ten:] “сайн” зэрэг үгтэй холбоотой гэж үзэж болох юм.

6. **šusan* / **šūsVn* [屬珊] (Юань улсын үеийн хятад хэлэнд **šy-san*) “шүр (珊瑚)”. Энэ үг *Ляо шы*-гийн 37-р бүлгийн 6-р хуудасны 1-р талд, 116-р бүлгийн 13-р хуудасны 2-р талд, *Ляо шы шы-и*-гийн 23-р бүлгийн 429 дахь талд байгаа бөгөөд монгол бичгийн *šürü, sirü, bsirü* “шүр”, халх, хорчин, жалайд, ар хорчин, баарин, шилийн гол, улаанцав, чахар, хэйлунцзянгийн дөрвөд аман аялгууны [ʃur] “шүр”, дагуур хэлний [sor] “тана”, манж хэлний *šuru*, солон хэлний [ʃur] “шүр” зэрэг үгтэй гарал нэгтэй гэж үзмээр байна. Америкийн эрдэмтэн Лауфер (Laufer) (1916:467) төвд хэлний *byi-ru* “шүр” гэдэг үгийг авч үзэхдээ самгарди хэлний *vidruma* гэдгээс гаралтай гэж үзжээ. Энэ нь кидан, манж болоод монгол төрлийн хэлнүүдийн хэлбэрүүдийн үндсэн эх байж болох юм.
7. **xaju(u)* [曷朮] (юань улсын хятад хэлэнд **xə-tʃy*, дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд **xɦaR-trɦyR*) “төмөр (鐵)”. Энэ үг *Ляо шы*-гийн 60-р бүлгийн 1-р хуудасны 2-р талд байгаа бөгөөд дагуур хэлний бутха аялгууны [kasoo], дагуур хэлний хайлаар аялгууны [xasoo], дагуур хэлний синьцзян (新疆) аялгууны [kazo] “төмөр” гэдэгтэй холбоотой байна. Японы эрдэмтэн Ширатори энэ кидан үгийг авч үзэхдээ бас зарим Самоди (Samoyedic) хэлнүүдэд тохиолддог төсөөтэй хэлбэрүүдийг дурдсан байдаг (1912:1266).
8. **xudadu* [胡大𪛗] (юань улсын хятад хэлэнд **xu-ta-tu*) “ходоод (胃)”. Энэ үг *Ляо шы*-гийн 116-р бүлгийн 15-р хуудасны 1-р талд байгаа бөгөөд монгол бичгийн *qoduyudu* “ходоод”, халх аялгууны [xəɖɔɖ] **ходоод**, хорчин, жалайд, ар хорчин, баарин, шилийн гол, улаанцав, чахар, горлос, хэйлунцзянгийн дөрвөд аялгууны [xəɖɔɖ] “ходоод” зэрэг хэлбэрүүдтэй гарал нэгтэй байна. *Ляо шы*-д байгаа галигласан нь үнэн хэрэг дээрээ [胡木𪛗] (Юань улсын үеийн хятад хэлний **xu-mu-məw*) бөгөөд энэ хэлбэрийн дагуу кидан хэлний **xututu* хэлбэр сэргээх ёстой боловч *Ляо шы*-д байгаа энэ галиг нь зарим нэг алдаатай байж магадгүй. Тухайлбал, 木 үсэг нь 大 (Юань улсын үеийн хятад хэлний **ta* ~ **taj*) үсгийг буруу бичсэн нь байж магадгүй бөгөөд 𪛗 (Юань улсын үеийн хятад хэлний **tu*) үсгийн таталган бичгийн хэлбэр нь 𪛗 (Юань улсын үеийн хятад хэлний **məw*) үсгийн таталган бичгийн хэлбэртэй нэлээд ойролцоо байна. Ийм учраас кидан хэлний **xudadu* гэсэн хэлбэрээр нь сэргээвэл үндэслэлтэй. Бас ингэж сэргээвэл, кидан хэлбэр нь монгол хэлний хэлбэртэй төсөөтэй болж ирнэ. Гэхдээ энэ үр дүнд хүрэхийн тул баримтыг нь засварлах хэрэгтэй учраас энэ сэргээсэн хэлбэрийг жаахан таамагласан гэж үзвэл зүйтэй.
9. **x^wa-* [化] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд **xwa:*), [樞] (юань улсын хятад хэлэнд **xwa*), “харва- (射)”. Энэ үг *Ляо шы*-гийн 53-р бүлгийн 7-р хуудасны 2-р талд, 116-р бүлгийн 11-р хуудасны 1-р талд, *Ци-дань Гуо-чжы*-гийн 27-р бүлгийн 186 дахь талд, *Ляо чжы*-гийн 8 дахь талд, *Янь бэй цзи-цзи*-д

байгаа бөгөөд монгол бичгийн *qarbu-* ~ *qabu-*, дагуур хэлний [xarəb-] “харва-”, халимаг хэлний [xa-] “харва-”, халх аялгууны [xarw-] **харва-**, горлос аялгууны [xarɪm-] “харва-” зэрэг хэлбэртэй гарал нэгтэй хэмээн үзмээр байна.

10. ***n^lair** [捏咿呢] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд **niaR-ʔji-ji*, Юань улсын үеийн хятад хэлэнд **nje-ji-ɣ*) “үүр, үүрийн гэгээ, өглөө, нар мандах (旦)”. Энэ үг *Ляо шы*-гийн 53-р бүлгийн 7-р хуудасны 2-р талд байгаа бөгөөд монгол бичгийн *nara(n)*, өвөг монгол хэлний **nara-n* “нар”, монгол дахь хамниган монгол хэлний [narā], дагуур хэлний [nar], монгол хэлний халх аялгууны [nar] **нар** зэрэг үгтэй холбоотой гэж үзмээр байна. Үүнээс гадна, хятадын эрдэмтэн Мэн Чжы-дун (孟志东) хятадын Юйнь-нань (云南) мужийн “киданчуудын хойчисын хэл”-эн дэх *niàni* “нар (太阳)” гэсэн хэлбэрийг тэмдэглэжээ (Мэн 1995:213). Энэ үг ч бас кидан хэлний **n^lair* гэдэгтэй гарал нэгтэй гэж үзүүштэй.

Кидан хэлний энэ үгийг Ширатори (1913:23), Лигети (Ligeti) (1927:308), Виттфогел ба Фэн (Wittfogel & Fêng) (1946:269), Кара (Kara) (1986-7:20; 1996:233), Чингэлтэй (2002:11, 58.159), Томпсон (Thompson) (2006:521) зэрэг нэлээд олон эрдэмтэн авч үзэхдээ тагнайшсан бус хамрын гийгүүлэгч **n*-тэй хэлбэрээр сэргээсэн байдаг. Гэхдээ энэ үг болон өөр кидан үгийн хятад үсгийн галигийг ажиглавал, тагнайшсан гийгүүлэгч **n^l*-ээр сэргээх нь зүйтэй санагдана. Түүнээс гадна, хэрэв ингэж сэргээвэл, нэг зүй тогтол бүхий дүйцэл (regular correspondence) гарч ирнэ. Юу гэвэл, кидан хэлний **n^l* - : монгол хэлний **n*-. Үүнд, дараахь хоёр үгийг үзмүү.

11. ***n^lagurdi-** [捏骨地] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд **niaR-kuR-tfi*) “өвдөглөх (跪)”. Энэ үг *Ци-дань гуо-чжы*-гийн 27-р бүлгийн 189 дэх тал, *Ляо шы шы-и*-гийн 24-р бүлгийн 435 дахь тал, *Ляо чжы*-гийн 11 дэх талд дурдагдсан бөгөөд Жинь (金) буюу Алтан улсын үеийн зөрчид хэлний **n^lagurdi-* [滅古地] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд **mjiaR-kuR-tfi*) “өвдөглөх (下跪)” (Сунь 2004:233, 330), Мин улсын зөрчид хэлний **n^lakuru-* [捏苦魯] (Юань улсын үеийн хятад хэлний **nje-k^hu-lə*) “өвдөглөх (跪)” (Kane 1989:287), сонгодог манж хэлний *n^laku-* “өвдөглөх”, манж хэлний бала аялгууны [mikurə-] “өвдөглөх” (ЧЖАО 2001:112), негидал хэлний [mixert-], ороц хэлний [mæxurana-], удихэ хэлний [mæula-], ульча хэлний [m^lakurandi-], орок хэлний [mēxorən-], нанай хэлний [mixoran-] “өвдөглөх” (Rozycki 1994:163; Цинциус 1975-1977) зэрэг үгтэй гарал нэгтэй гэж үзмээр байна. Франке (Franke 1969:40-1), Ширатори (1913:23), Штайнь (Stein 1940:149) зэрэг эрдэмтэн энэ кидан үгийг авч үзсэн байдаг.

12. *n¹alu- [雅魯] (дундад үеийн хятад хэлний хожуу үеийн хэлэнд *ŋja:-lu) “мэхийгээд бүжиглэх (拜舞)”. Энэ үг *Ци-дань гуо-чжы*-гийн 24-р бүлгийн 173-р талд байгаа бөгөөд Вовинь (2003:241) түүнийг сэргээгээд монгол бичгийн *nalu*- “тонгойх, бөхийх, г.м.” гэдэгтэй гарал нэгтэй гэж үзсэн байдаг. Вовинь-оос өмнө, Франке (1976) болон Ширатори (1912:1248) энэ үгийг авч үзжээ. Хэв шинж судлалын хувьд энэ үг болон дээр дурдсан хоёр үг кидан хэлэнд тагнайшсан гийгүүлэгч байсаны гэрч хэмээн үзэж болно. Бас ингэж үзвэл, эдгээр үгийг Пеллио (Pelliot)-гийн кидан хэлийг “их тагнайшсан” (*très palatalisée*) хэл хэмээн үзсэн (1929:127)-ий баталгаа гэж үзүүштэй.

Энэхүү өчүүхэн өгүүллээ профессор Дениш Шинор (Denis Sinor) гуайн 90 насны ой болон алтай хэлнүүд, төв евразийн түүх судлалын талаар түүний хийсэн, их үр нөлөө бүхий судалгааны ажилд зориулмай.

Номзүй

Латин үсгээр:

- Coblin, W. South (1991) *Studies in Old Northwest Chinese* [= Journal of Chinese Linguistics, Monograph Series, No. 4], Berkeley, California: University of California.
- Coblin, W. South (1994) *A Compendium of Phonetics in Northwest Chinese* [= Journal of Chinese Linguistics, Monograph Series, No. 7], Berkeley, California: University of California.
- Csongor, Barnabás (1953) “Chinese in the Uighur script of the T’ang-period”, *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 2, pp. 73-121.
- Csongor, Barnabás (1954) “Some more Chinese glosses in Uighur script”, *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 4, pp. 251-257.
- Csongor, Barnabás (1960) “Some Chinese texts in Tibetan script from Tun’-huang”, *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 10, pp. 97-140.
- Csongor, Barnabás (1962) “Chinese glosses in Uighur texts written in Brahmi”, *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 15, pp. 49-53.
- Franke, Herbert (1969) “Bemerkungen zu den sprachlichen Verhältnissen im Liao-Reich”, *Zentralasiatische Studien* 3, pp. 7-43.
- Franke, Herbert (1976) “Two Chinese-Khitan macaronic poems”. In: W. Heissig, J. R. Krueger, F. J. Oinas, and E. Schütz (eds.). *Tractata Altaica*, Wiesbaden: Otto Harrassowitz.
- Kane, Daniel (1989) *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters* [= Indiana University Uralic and Altaic Series, Vol. 153], Bloomington, Indiana: Indiana University Research Institute for Inner Asian Studies.
- Kara, György (John R. Krueger opч.) (2005) *Books of the Mongolian Nomads: More than Eight Centuries of Writing Mongolian*, [= Indiana University Uralic and Altaic

Series, Vol. 171], Bloomington, Indiana: Indiana University Research Institute for Inner Asian Studies.

Laufer, Berthold (1916) "Loan-words in Tibetan", *T'oung Pao*, Vol. 17, p. 467.

Ligeti, Louis [Lajos Ligeti] (1927) "A kitaj nép és nyelve", *Magyar Nyelv*, Vol. 23, pp. 301-310.

Ligeti, Louis [Lajos Ligeti] (1950) "Mots de civilization de la Haute Asie en transcription chinoise", *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 1, pp. 141-185.

Pelliot, Paul (1929) "L'édition collective des oeuvres de Wang Kouo-wei", *T'oung Pao* 26, pp. 113-200.

Pulleyblank, Edwin G. (1984) *Middle Chinese: A Study in Historical Phonology*, Vancouver: University of British Columbia Press.

Pulleyblank, Edwin G. (1991) *Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin*, Vancouver: University of British Columbia Press.

Rozycki, William (1994) *Mongol Elements in Manchu* [= Indiana University Uralic and Altaic Series, Vol. 157], Bloomington, Indiana: Indiana University Research Center for Inner Asian Studies.

Stein, Rolf-Alfred (1940) "Leao-tche", *T'oung Pao* 35, pp. 1-154.

Thomson, Mikael [Томпсон] (2006) "Scripts, Inner Asian". In: *Encyclopedia of Language & Linguistics*, 2nd edition, Boston: Elsevier, pp. 519-534.

Vovin, Alexander (2003) "Once again on Khitan words in Chinese – Khitan mixed verses" *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*, Vol. 56 (2-4), pp. 237-244.

Wittfogel, Karl A. and Fêng Jia-Sheng (1946) *History of Chinese Society: Liao (907-1125)* [= Transactions of the American Philosophical Society, New Series 36], Philadelphia.

Хятад хэлээр:

Дин Шы-цин 丁石庆 (1995) "Синь-цзян да-во-эр-юй цзянь-шу" 新疆达斡尔语简述, *Юй-янь янь-цзю* 语言研究, Vol. 28, pp. 188-195.

Е Лун-ли 葉隆禮 (1968), *Ци-дань гуо-чжы* 契丹國志, Тай-бэй 臺北: Тай-вань шан-у инь-шу-гуань 臺灣商務印書館.

Е Лун-ли 葉隆禮 (1985) *Ляо чжы* 遼志, Бэй-цзин 北京 [Бээжин]: Чжун-хуа шу-цзю 中華書局.

Kara, György (Фан Ли-цзюнь 范丽君 орч.) (2004) *Мэн-гу-жэнь дэ вэнь-цзы юй шу-цзи* 蒙古人的文字与书籍 [= Мэн-гу ли-шы вэнь-хуа вэнь-ку 蒙古历史文化文库], Ху-хэ-хао-тэ 呼和浩特 [Хөх хот]: Нэй-мэн-гу жэнь-минь чу-бань-шэ 内蒙古人民出版社.

- Ли Э 厲鶚 (1985) *Ляо шы шы-и* 遼史拾遺, Бэй-цзин 北京 [Бээжин]: Чжун-хуа шу-цзю 中華書局.
- МЭН Чжы-дун 孟志东 (1995) *Юйнь-нань ци-дань хоу-и янь-цзю* 南契丹后裔研究, Бэй-цзин 北京 [Бээжин]: Чжун-гуо шэ-хуй кэ-сюэ чу-бань-шэ 中国社会科学出版社.
- Сунь Бо-цзюнь 孙伯君 (2004) *Цзинь-дай ной-чжэнь-юй* 金代女真语, Шэнь-ян 沈阳: Ляо-нин минь-цзу чу-бань-шэ 辽宁民族出版社.
- Тото 脫脫 [Тогтоо] (1927, 1936 оны хооронд) *Ляо шы* 遼史, Шан-хай 上海 [Шанхай]: Чжун-хуа шу-цзю 中華書局.
- ЧЖАО А-пин 赵阿平 (2001) *Хэй-лун-цзян сянь-дай мань-юй янь-цзю* 黑龙江现代满语研究, Ха-эр-бинь 哈尔滨: Хэй-лун-цзян цзяо-юй чу-бань-шэ 黑龙江教育出版社.
- Чингэлтэй [Цин-гэ-эр-тай 清格尔泰] (2002) *Ци-дань сяо-цзы шы-ду вэнь-ти* 契丹小字釋讀問題, Дун-цзин 東京 [Токио]: Гуо-ли я фэй юй-янь вэнь-хуа янь-цзю-суо 国立亞非語言文化研究所.

Япон хэлээр:

- ШИРАТОРИ Күракичи 白鳥庫吉 (1912) “Тоокоо минзоку коо”, 東鳥民族考, *Шигаку заиши* 史学雜誌 23, pp. 1243-1269.
- ШИРАТОРИ Күракичи 白鳥庫吉 (1913) “Тоокоо минзоку коо”, 東鳥民族考, *Шигаку заиши* 史学雜誌 24, pp. 17-45, 854-884.
- ЯМАМОТО Кэнго 山本謙吾 (1969) *Манишүүго коого кисогой шүү* 滿洲語口語基礎語彙集, Тоокёо 東京 [Токио]: Тоокёо гайкокуго дайгаку 東京外国語大学.

Кирилл үсгээр:

- Амаржаргал, Б. (1988) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг I. Халх аялгуу*. Улаанбаатар: БНМАУ-ын ШУА, Хэл зохиолын хүрээлэн.
- Тодаева, Б.Х. (1981) *Язык монголов внутренней монголии: материалы и словарь*. Москва: Издательство “НАУКА”.
- Цинциус, В. И. (1975-1977) *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков: материалы к этимологическому словарю*. Ленинград: НАУКА.